

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2020-01-29/**

Ажлын хэсгийн 2020 оны анхдугаар буюу 50 дугаар хуралдаан 2020 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн 14.00 цагт Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2 дугаар хурлын танхимд зохион байгуулагдав.

Ажлын хэсгийн хуралдаанд УУХҮЯ-ны Эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийн дарга Д.Дамба, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Ч.Чимидсүрэн, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Авилгатай тэмцэх газрын ажилтан Н.Ганхуяг, Цэнд-Аюуш, Татварын ерөнхий газрын байцаагч Ж.Батцэнгэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагч Н.Мөнхцэцэг, Бадрах энерги ХХК-ийн олон нийтийн харилцааны мэргэжилтэн Н.Оч, Бороо гоулд ХХК-ын мэргэжилтэн Т.Мөнхзул, Эрдэнэс Монгол ХК-ийн мэргэжилтэн Н.Баттулга, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Оюутолгой ХХК-ийн мэргэжилтэн Н.Ренчинпагма, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын тэргүүн Д.Сүхбаатар, Захиргааны шинэ санаачилга ТББ-ын тэргүүн Д.Цэрэнпүрэв, Их баян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор, МБОИЗ-ын удирдах зөвлөлийн гишүүн Н.Эрдэнэсайхан, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 19 гишүүн оролцож, ирц 57,6 хувьтай байв.

Мөн хуралдаанд Азийн хөгжлийн банкны зөвлөх Э.Энэрэлт, ажлын албаны санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, мэдээллийн технологийн зөвлөх О.Мөнхбат нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны ЭЗХОС-ны хэлтсийн дарга Д.Дамба удирдан явуулав.

**Танилцуулга нэг: Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө**

Д.Дамба: УУХҮЯ-наас хэрэгжүүлэх 2016-2020 оны Мастер төлөвлөгөөний дагуу 2020 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг товч танилцуулъя.

Тус яам Эрдэс баялгийн салбарын хүрээнд 2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ны 25 хувь, Аж үйлдвэрийн бүтээгдхүүний 75 хувь, экспортын бүтээгдхүүний 90 гаруй хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73 хувийг дангаараа бүрдүүлсэн статистик мэдээ гарлаа. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдхүүний үйлдвэрлэл 17,5 их наяд төгрөг хүрснээс уул уурхайн салбарын үйлдвэрлэл 12,3 их наяд төгрөг буюу өмнөх оныхоос 1,1 их наяд төгрөгөөр өссөн байна. Нүүрс, газрын тос, хайлуур жоншны үйлдвэрлэл өмнөх оныхоос 1,6-54 хувиар өсч улсын төсөвт 2,9 их наяд төгрөг төвлөрүүлсэн байна. Тус яам 2019 онд салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулах, дэд бүтцийг сайжруулах, стратегийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх, газрын тосны бүтээгдхүүний үнэ, тогтвортой байдлыг хангах, хүнд үйлдвэрлэлийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг зорилтыг тавьж ажилласан. Олборлох үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага үйл ажиллагаа эрхлэх журам, Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Уурхайн хаалтын журам зэрэг эрх зүйн баримт бичгийг боловсруулж, батлуулж ажилласан байна. Мөн бичил уурхайн үйл ажиллагааг цэгцлэх, хууль бусаар олборлох үйл ажиллагааг таслан зогсоох талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн байна.

2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дурдвал, ирэх 20-30 жилд манай салбар тэргүүлэх салбар байх нь тогтоогдсон. Үүнд оролцогч талууд, бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд хамтран ажиллах нь хамгаас чухал байгаа. Тухайлбал,

ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хамтын ажиллагаа, оролцоо чухал гэдгийг та бүхэнд хэлье.

УУХҮЯ энэ оноос эхлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж байгаа. Төлөвлөгөөний төсөл нь гарчихсан, газар хэлтсүүд ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд Эрдэс баялагийн ил тод байдлын хуулийн төслийг батлуулах, Санаачилгын зарчмыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх гэсэн хоёр том зорилт орсон байна. Хуулийн төслийг боловсруулж батлуулах ажлын хүрээнд өмнөх ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлж ажиллуулна, хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулах улмаар хуулийн төслийг Засгийн газрын хуралдаан болон Улсын их хурлын байнгын хороо цаашлаад УИХ-д өргөн барих ажлыг зохион байгуулна. Энэ хүрээнд бусад сурталчилгаа хийх ажлууд хамрагдана.

Хоёр дахь зорилтын хүрээнд ОУИТБС-ын стандартын шинэ шаардлагын дагуу тайлангийн маягыг шинэчлэн боловсруулж, батлуулах, батлагдсан тайлангийн маягыг аж ахуйн нэгжүүдэд дагаж мөрдүүлэх, хяналт тавих, хэрэгжилтийг хангах ажлыг хийнэ. ОУИТБС-ын 2019 оны тайлан гаргуулах зэрэг ажлууд хийгдэнэ. Манай яам, Төрийн бус байгууллагуудтай хамтран 500 гаруй гэрээг ил тод болгосон, цаана нилээн олон гэрээг ил тод болгохоор шат шатандаа хянагдаад явж байна.

Өнгөрсөн 2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлтөд манай салбартай холбоотой 6,2 дугаар заалтад Баялагийн сантай болно гэсэн том концепц дэвшүүлсэн. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, дээрх заалтыг хэрэгжүүлэхийн тулд УУХҮЯ-нд том ажлын хэсэг, техникийн ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна. Хууль хэрэгжиж эхлэхээс өмнө органик хуулиудад зарчмын өөрчлөлт оруулах ажлууд хийгдэнэ. Байгалийн баялагаас орж байгаа орлогыг баялагийн сан байгуулах замаар иргэдэд тэгш хүртээмжтэй хуваарилах заалтын хүрээнд Баялагийн сангийн хууль ажлын хэсгийн түвшинд боловсруулж байна. Саяхан эхний төсөл нь гараад, яамны удирдлагуудад танилцуулагдсан, ирэх долоо хоногоос Засгийн газраас байгуулсан ажлын хэсэгт танилцуулагдаад, Засгийн газрын хуралдаан, холбогдох байнгын хороонд танилцуулах ажлууд эрчимтэй явагдана. Цаашдаа хуулиуд дээр түлхүү ажиллана, энэ хүрээнд манай Ажлын хэсгийн ажил уялдаад явна гэж ойлгож байгаа.

Хуралдааны хэлэлцэх асуудал болон дэгийг уншиж танилцуулав.

#### **Танилцуулга хоёр: Монголын ОУИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний товч танилцуулга**

Ш.Цолмон: Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хурлаар ОУИТБС-ын 2020 оны төлөвлөгөөг хэлэлцсэн, Ажлын хэсэг болон Азийн хөгжлийн банкуудаас санал авсан. Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, УУХҮЯ, АХБ-аас санал авсны үр дүнд 2020 оны оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 14 зорилт, 59 үйл ажиллагаа бүхий Монголын ОУИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөр батлуулсан билээ.

2020 оны Гол уриа 2019 оны шинэ стандартыг сурталчлах, Орон нутгийн дэд зөвлөлийг чадавхжуулахад чиглэж байна.

Энэхүү нэгдүгээр зорилгын хүрээнд 14 үйл ажиллагааг төлөвлөж байна. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлснээр шинэ шаардлагад нийцсэн тайлангийн маягтай болж, компаниуд, төрийн байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүд мэдлэг, чадавхтай болж, тайланг хугацаандаа гаргах боломжтой болно. Шинэ маягтуудыг Үндэсний статистикийн хороотой хамтран боловсруулж байна. 1 дүгээр сардаа багтаан дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноо, бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар тодорхой мэдээлэл ил тод болох ёстой. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл илүү

ил тод болсноор тэдний үйл ажиллагаа олон нийтэд ойлгомжтой болно. Шинэ шаардлагуудын дагуу ОУИТБС-ын цахим сүлжээг өргөтгөж байна. Гэрээний ил тод байдлыг хангах талаар 2019 онд томоохон ахиц дэвшил гарсныг Дамба дарга дурдсан байгаа.

Хэвшүүлэн ил тод болгох талаар Засгийн газрын холбогдох шийдвэрийг гаргуулах талаар энэ жил нилээд хүчин чармайлт тавих хэрэгтэй байна. Өчигдрийн мэдээгээр энэ оны 3 дугаар сард манай улсад ОУНБ-ын газраас техникийн зөвлөх ирэхээр болсон. Хэвшүүлэн ил тод болгох ажилтай уялдан төрийн байгууллагуудын цахим системтэй танилцах төлөвлөгөөтэй байна гэсэн.

2-р зорилтын гол ажил бол Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийг дахин боловсруулж, УИХ-аар батлуулах зорилгын хүрээнд хийгдэх ажлыг сая танилцуулсан. Хамгийн гол нь 4-р сард багтаан хаврын чуулган эхэлмэгц УИХ-д өргөн барих төлөвлөгөөтэй байгаа, яамнаас ч ийм шаардлага тавьж байгаа.

2016 онд Үндэсний зөвлөлөөр батлагдсан “Ашиг хүртэгч эздийг ил болгох” замын зургийн биелэлтийг хангахад 2 зорилт, 6 үйл ажиллагааг 3-р зорилгын хүрээнд төлөвлөсөн 2020 оны төлөвлөгөөнд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг” (ХАСХОМ)- ийг бага зэрэг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах чиглэл байгаа. Энэ ажилтай холбоотойгоор ажлын хэсэг АТГ-т байгуулагдан ажиллаж байгаа гэж ойлгосон. Үүнд, компаниудын эздийг хамруулах талаар ямар ажил хийх талаар болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хамтран ажиллах хэрэгтэй байгаа.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд Монголын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэл тайланг хугацаанд нь чанартай гаргах ажлын зохион байгуулна. 2021 оны 2 дугаар сард манай улсын ОУИТБС-ын баталгаажуулалтын үнэлгээг хийлгэх тул 2019 оны тайлан нилээд чанартай хийгдэх шаардлагатай байгаа.

Тавдугаар зорилгын хүрээнд Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр нөлөө, ач холбогдол, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг идэвхжүүлэхэд 6 зорилт бүхий 20 үйл ажиллагаа төлөвлөгдсөн байгаа эдгээр ажлуудыг мэргэжлийн холбоод, төрийн бус байгуулагууд, орон нутгийн удирдлага, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Харин Дэд зөвлөлийн туршлага солилцох зэрэг ажлыг ямар хэлбэрээр хийх талаар эргэн бодох, санал солилцох хэрэгтэй гэж Азийн хөгжлийн банкнаас сануулсан байгаа, бүсийн чуулганууд төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.

Та бүхэн ОУИТБС-ын 2020 оны ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах санал байвал өгч болно. Энэ онд Үндэсний зөвлөлийн хуралдааныг 2 удаа, Ажлын хэсгийн хурлыг 5 удаа зохион байгуулах санал оруулж байна.

Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Норвеги улсад айлчлах үеэрээ ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн дарга газар, Удирдах хорооны удирдлагатай уулзсан байна. Уулзалтын үеэр Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийг батлуулах, Эцсийн өмчлөгчийг ил тод болгох талаар зэрэг хэд хэдэн асуудлаах хамтарч ажиллахаар тохиролцсон мэдээтэй байна. Энэхүү уулзалтаар оны 10 дугаар сард болох ОУ-ын Удирдах хорооны хуралдааныг манай улсад зохион байгуулах талаар мөн ярилцсан байна. Үүнд Монгол улс зохион байгуулалтын тал дээр нилээд оролцох, бэлтгэл ажлыг хангах талаар чиглэл өгсөн байгаа.

Энэ мэтчилэн 2020 онд нилээд томоохон ажлууд хийгдэхээр хүлээгдэж байна, үүнийг дагаад үр дүнгүүд гарна гэж бодож байна. Ингээд та бүхэн 2020 оны ажлын төлөвлөгөөгөө нарийвчлаад, хэрэгжүүлэх талаар хамтран ажиллана гэдэгт найдаж, талархаж байна.

Д.Дамба: Хуралдааны дэгийн дагуу танилцуулсан төлөвлөгөөтэй холбоотой асуулт тавиад, саналаа хэлж болно.

Н.Баярсайхан: Баталгаажуулалт хэзээ болох вэ? тусдаа төлөвлөгөө гарах уу? 2018 оны нэгтгэл тайлангийн дагуу зөвлөмжүүд төлөвлөгөөнд орсон байна үүний 13.5 ажил ойлгомжгүй байна, тайлбарлаж өгнө үү. 2020 оныг Дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгохоор зорилт тавьсан, үүний тулд ямар тодорхой ажлуудыг хийх болон жилийн нийт төсвийн хэдэн хувь нь энэ ажилд зарцуулагдах вэ, ямар үр дүн гарах вэ бид хүлэээгдэж байгаа үр дүнгээ тодорхойлоогүй юм шиг харагдаад байна. Тодорхой үр дүнд хүрэхийн тулд жижиг төлөвлөгөө гаргамаар байна, энэ бол ажлын жагсаалт болоод байна. Төлөвлөгөөнд ямар ажлуудыг ямар алхамаар хийх, ямар үр дүнд хүрэхийг тодорхой тусгамаар байна.

Ш.Цолмон: Баталгаажуулалт 2021 оны 2 сард эхэлнэ гэсэн мэдээтэй байгаа. 2021 онд 10-аад орон баталгаажуулалтад орохоор байгаа. Стандартын дагуу өөрийн үнэлгээ хийх ажил байгаа. Бид өөрсдөө үнэлээд, асуумжаар асуугаад хоорондоо хэлэлцээд, нэгдсэн байр суурийг нэгтгээд ОУНБГ-т хүргүүлнэ. Төлөвлөгөөний 13.5-ийг БДО аудитын зөвлөмжийн дагуу оруулсан. Төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх талаар календарчилсан төлөвлөгөөг боловсруулж байгаа, төслийн зохицуулагч Баярхүү хянаж байгаа, эцсийн байдлаар та бүхэнд явуулж санал авах байх. Дүгнэх аргачлал боловсруулахаар ажиллаж байна.

Д.Дамба: Энэ оноос бүх төрийн байгууллагууд тодорхой зорилт дэвшүүлээд түүнд хүрэхийн тулд үйл ажиллагаагаа тодорхойлоод, тэр нь чанар болон тоо хэмжээний хэмжигдэхүйц тодорхой байх ёстой. Бид яамны төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлаа тодорхой нарийвчлан хийхээр мэргэжилтнүүд тус тусын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаад, ажиллахаар төлөвлөж байгаа. Ажлын хэсгийг 5-аас доошгүй, Үндэсний зөвлөлийн хурлыг 2-оос доошгүй удаа хуралдуулна гэхэд үүнийг хэзээ зохион байгуулах цаг хугацааг тодорхой нарийвчлан оруулна.

Н.Цэнд-Аюуш: Төлөвлөгөөнд дурдсан ажлуудыг тухайн үед нь хамтраад хийх боломжтой гэж үзэж байна. 2019 онд батлагдсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд тайлан гаргуулах ажил орсон. Бид саяхан хөтөлбөрийн зорилт хэрхэн хангагдаж байна гэдгийг судалж төрийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийсэн, түүнээс гарсан зөвлөмжийг Засгийн газарт танилцуулна. Цаашдаа төлөвлөгөөг биелүүлэхэд хамтран ажиллах, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллана. Хөрөнгө оруулгын мэдээллийн маягтыг шинэчлэх ажил явагдаж байна, өгөх санал байвал нэгтгээд өгч болно. 2012 онд Засгийн газрын тогтоолоор анх ХОМ-ын маягтыг батласан байдаг одоо үүнийг мөрдөж байгаа, шинэчлэх шаардлагатай байна.

Д.Дамба: За баярлалаа, бид цаашдаа АТГ-тай нягт хамтран ажиллах болно. Төслийн зохицуулагч Баярхүү маань яам болон ажлын албаны хооронд зохицуулалт хийж ажиллана. Яаман дээр сууж байгаа, Ажлын алба яамны үйл ажиллагаа улам ойртож байгаад баяртай байна, хамтран ажиллах болно.

Л.Бор: Уул уурхайн компаниуд ОУИТБС-ын талаар ойлголт муу байна, ялангуяа миний ажилладаг ураны Үндэстэн дамнасан компаниуд, корпорациуд санаачилга, хариуцлагатай уул уурхай, Нээлттэй нийгэм форум болон ТАН эвслийн талаар мэдлэг мэдээлэл байхгүй байна. Тэдгээр компаниудын удирдлагад манай байгууллагуудтай хамтран ажиллах талаар санал тавих хэрэгтэй байна.

Гэрээнүүд ерөнхийдөө ил болж байгаа боловч зарим гэрээг нууц гээд байдаг иймээс ямар гэрээг яаж ил болгох талаар оруулмаар байна. Мөн Олон улсын гэрээн дээр ажилладаг чадавхи, мэдлэгтэй өөрийн боловсон хүчинтэй болмоор байна.

Орон нутгийн Дэд зөвлөлийг хэрхэн ажиллуулах, гаднын байгууллагууд санхүүжүүлэх боломжгүй бол өөрсдийн дотоодын төсвөөс санхүүжүлдэг болмоор байна. Өчнөөн жил зөндөө тусламж авсан ч энэ нь дэд зөвлөлд хүрээгүй байгаа, бид мэтийн

санаачилгатай хүмүүс жаахан ажиллаж байгаа болохоос хүрч ажиллаж чадахгүй байгаа. Иймд төсвөөс санхүүжүүлэх зайлшгүй шаардлага байна.

Уул уурхайн салбарын бодлого гэдэг бол санаачилгаас өөр юм, би буруу бодож байж магадгүй. Санаачилга гэдэг нь улс орнууд өөрсдөө байгалийн баялагтай эзэн болж, түүнээс орж байгаа орлогыг нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахыг хэлэх байх. Санаачилгаар бүх юмыг хэрэгжүүлэх нь Монгол улсын төрийн бодлого биш юм харин санаачилга нь төрийн бодлогын нэг хэсэг байх болов уу гэж бодож байна.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор бусад хуулиудад өөрчлөлт оруулахаар ярьж байна, Ашигт малтмалын тухай хууль гэх мэт холбоотой олон хуулиудад дутуу юм байгаа, хайгуулын лицензийн хугацаа хуулиараа 12 жил гэж байхад АМГТГ-аас 17 жил болгоод сунгаад байдаг үүнийг өөрчлөх нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал байтал АМГТГ хийгээд байна. Мөн ашиглалтын зөвшөөрөл авчихаад алга болсон компаниуд байна, ашиглалтын өмнөх 3 жил гэдэг нь хуульд байхгүй болсон гэх мэт олон асуудлыг дотооддоо ярьмаар байна. Мөн байгалийн баялагийн сантай болно гэж байна үүнийг хэрвээ төр мэдэх юм бол учир дутагдалтай байх болно энэ талаар сайн ярилцах хэрэгтэй байна. Баялагийн ашиглалтын хувь хуулиуд дээр өөр өөр байдаг үүнд нухацтай ажиллахгүй хэрэгтэй.

Д.Дамба: Таны тавьсан асуудал, санал шүүмжлэлийг хүлээн авч байна. Орон нутгийн түвшинд хангалтгүй ажиллаж байна гэдэгтэй санал нийлэхгүй байна. Баялагийн санг байгуулахаар болсон.

Ч.Чимидцэрэн: Төлөвлөгөөний 8 дахь зорилтын хүрээнд хийгддэг ОУИТБС-ын нэгтгэл тайлан гаргах Аудитын компани сонгон шалгаруулалтыг эрт хийх хэрэгтэй байна. Хэрвээ тэгэж чадвал мэдээ мэдээллээ авах, нэгтгэх зэрэг ажлыг хийхэд тустай болно. Энэ жилийн байдлаар бас л 5 сар хүрэх юм шиг байна. Бид 2018 оны мэдээ тайланг 2020 онд яриад байдаг тиймээс аудитын компанийн сонгон шалгаруулалтын хугацааг авч үзэх саналтай байна, мэдээллийн ач холбогдол гэж байна. Нэгтгэл тайлан хийхдэж, мэдээ цуглуулахад явцад аудитын компанид хувийн байгууллагад хандах хандлагыг харуулдаг. Иймд ЗГХЭГ юмуу төрийн байгууллагаас мэдээ тайланг бэлтгэн гаргаж өгөх талаар шийдвэр гаргаж өгмөөр байна. Өнгөрсөн жилүүдэд нэгтгэл тайлангийн зорилгоор мэдээ тайлан авах болоход байгууллагын нууц, өгөх боломжгүй зэрэг асуудал тулгардаг. Иймд үүнийг албажуулж, тайлангийн мэдээллээ хэрхэн яаж авах талаар боловсруулж, хүндрэлгүй хялбар болгох талаар ажил төлөвлөх боломж байгаа болов уу. Төлөвлөгөөний 13 дээр Нэгтгэл тайланг хийсэн Аудитын компаниас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хойш тавиад, цааргалаад байх шаардлагагүй иймд хэрэгжүүлэх хугацааг урагшуулах саналтай байна. Зөвлөмжийн дагуу харъяалагдах байгууллагад хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллах нь зүйтэй.

Д.Дамба: Баярлалаа. Өнгөрсөн жил нэгтгэл тайлангийн сонгон шалгаруулалт удааширсан нь үнэн, энэ жил үнэлгээний хороо байгуулагдах шатандаа явж байна.

Д.Сүхбаатар:Цахим тайлангийн мэдээллийн хэрэглээг хангах талаар ажилламаар байна. Зарим төрлийн мэдээллүүд хуучирсан 2016, 2017 оны мэдээлэл байна. Мэдээллийн шинэчлэлийн шуурхай хийх хэрэгтэй.

Ш.Цолмон: Мэдээллийг шинэчлэх ажил учир дутагдалтай байх, анхаарч ажиллана.

Н.Баярсайхан: Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 7 дээр УБГ, Ашигт малтмалын газар гэх мэт байгууллагуудад сургалт хийнэ гэж байна. Үүнийг сургалт биш хэлэлцүүлэг болгож өөрчлөх саналтай байна. Бид одоо хэвшүүлэн ил тод байлгах чиглэлд явах хэрэгтэй байна. Олон жил гаднын санхүүжилтээр явлаа, цаашдаа УУХҮЯ ажлын албыг тогтмол санхүүжилттэй болгож, үйл ажиллагааг нь хэвшүүлэх шаардлагатай.

Бид нэгэнт бий болгосон мэдээллээ ашиглахгүй байна, яам болон бусад байгууллагууд ч адилхан. Цаашдаа салбарын судалгаандаа мэдээллийг ашигладаг болмоор байна. Зөвлөмжид ОУИТБС-ын тайлан УИХ-ын Төсвийн байнгын хороонд танилцуулахаар тусгадаг боловч хэрэгжүүлж чадахгүй байгаа үүнийг хийх хэрэгтэй. Аймаг, орон нутгийн удирдлагуудад ОУИТБС-н тайланг судалгаа болон, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд ашиглах тухай Төрийн байгууллагаас үүрэг болгох хэрэгтэй. Бид өмнө нь 2 удаа баталгаажуулалтад орж байсан тухайн үед ямар сургамж, зөвлөмжүүд гарч байсан бэ? үүнийгээ ажлын алба эргэж хараад тусдаа төлөвлөгөө гаргаж ажиллах, баталгаажилтад орох гэж байгаатай холбоотойгоор, урьд нь хийгдэж байсан ажлуудын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийг эргэн харах. Түүн дээрээ үндэслэн ажлын хэсэг, төлөвлөгөө гарган ажиллаж, хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Олон улсын дарга нарын зөвлөлд захидал илгээж Төрийн хэвшүүлэн ил тод байлгах тал дээр техникийн болон арга зүйн тусламж авах талаар өмнөх хуралд санал гаргаж байсан энэ ажил юу болж байна?

Ил тод байдлын тухай хуулийг өмнө нь ЕСБХБ-наас хөрөнгө гаргаад нилээд сайн боловсруулсан, одоо АХБ-ын санхүүжилтээр хөрөнгө гаргах юм байна. Хууль санаачилсан гээд мөнгө авдаг, энийг хэн нь авах нь хамаагүй гэхдээ байж байгаад л нэг төслөөс мөнгө гаргаад хууль боловсруулаад яваад байх уу? үүнийг анхаармаар байна. Одоо байгаа 36 сая төгрөгөө нөлөөллийн ажилд зарцуулах саналтай байна.

Ажлын хэсгийн хурлыг жилдээ 5 удаа хийхээр төлөвлөсөн байна, үүнд Нандинжаргал дарга анхаарал хандуулсан байх. Одоо 5 дугаар сард болох хуралд Дэд зөвлөлийг чадавхижуулах талаар ямар ажил хийх хэрэгтэй байгаа талаар судалгаа хийх санал байна. Энэ ажлын хүрээнд АХБ-наас төсөв гаргаж болох уу, хэрвээ зөвшөөрвөл ТАН эвсэл санхүүжилт аваад, дэд зөвлөлүүдэд ямар арга аргачлал, туслалцаа хэрэгтэй байгааг судалж, төсөл боловсруулъя. Үүнийг дараагийн сургалтуудаар танилцуулж, хэлэлцүүлээд саналыг тусгаж ажилламаар байна. Зорилтын хүрээнд Дэд зөвлөлийн арга зүйтэй, хаанаас санхүүжих төсөвтэй болчихвол 2020 оны ажлын үр дүн болох юм.

Д.Дамба: За баярлалаа, манай төрийн байгууллагууд ажлын төлөвлөгөөндөө тусгаад, уялдуулж ажиллавал сайн байна.

Ж.Батцэнгэл: Сургалт гэснээс хэлэлцүүлэг байсан нь дээр байх. Хэлэлцүүлэг гэхээр баахан юм яриад мэдээд байгаа ч юм шиг мэдэхгүй юм шиг болдог. Намар 10 дугаар сард Татварын ерөнхий газар Ажлын албатай хамтраад татварын байцаагч нарт сургалт хийсэн. Сургалтаар ийм юмыг ингэж гаргана, хийнэ гэдэг байдлаар хийсэн нь дээр байх гэсэн санал байна. Төлөвлөгөөний 2.1 дээр лицензийн шилжилт хөдөлгөөн гэж оруулмаар харагдаж байна.

Г.Оюунтуяа: Манай сайт дээр сар бүр шилжилт хөдөлгөөний мэдээлэл гардаг, хэн ч харах боломжтой.

Н.Эрдэнэсайхан: Төлөвлөгөөний зорилт 3-ийн хүрээнд Гэрээний хэрэгжилтийн мониторинг, судалгаа хийх танилцуулах гэсэн байна. Цаг хугацааны хувьд зөвлөмж хийх ажил нь эхлээд, дараа нь мониторинг хийхээр оруулсан байна, үүнийг залруулмаар байна. Үүнд анхаарал тавиад дэлгэрэнгүй оруулж ирмээр байна.

Н.Мөнхцэцэг: Тайлан гаргаж байгаа хугацааны хувьд жилдээ нэг удаа байхаар тусгах нь зөв байх.

Н.Баярсайхан: Энэ асуудлыг би оруулсан, энэ нь гэрээний засаглалд мониторинг хийх ажил юм. Жил бүр төлөвлөгөө гаргаад хэрэгжилтийн байдалд мониторинг хийхгүй орхидог, үүнийг хэрэгжүүлэх талаар оруулсан санал юм.

Д.Цэрэнжав: ОУИТБС-ын гол цөм нь Нэгтгэл тайлан байдаг. Бидний 13 жилийн турш шийдэж чадаагүй асуудал бол цаг хугацаа байдаг. Тайлан гаргаж дуусахад мэдээлэл хуучирсан байдаг. ОУИТБС-ын ажлын албаны чадавхийг сайжруулж, орон тоог нэмэгдүүлэх замаар байнгын орон тоотой болж, ОУИТБС-ийн мэдээллийг цаг тухайд нь гаргаж баймаар байна.

Мэдээллийг хурдан шуурхай хүргэхийн тулд гэрээний цахим сайт нээсэн байгаа. Ажлын албаны чадавхийг нэмэгдүүлж, мониторингийг байнга хийдэг өөрөөр хэлбэл ажлын албыг мэдээллийн том төв болгох шаардлага байна. Гарын үсэг зурсан гэрээг ил тод болсон гэж үзэхгүй, гэрээ зурснаас хойш гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх зэрэг тасралтгүй үйл ажиллагаа явагдаж байдаг. Мэдээллийн өгөгдөл гэх мэт мэдээллийг хурдан түгээх ажлыг залуучууд хийж байна үүний хажууд манай тайлан динозавар шиг удаан байна. Үүнийг анхаарч ажиллах саналтай байна.

Д.Дамба: Бид энэ жилийн тайланг чадвал хагас жилдээ багтаан гаргуулах төлөвлөгөөг дотроо бодож байгаа, 2006 оноос хойш тайлан гаргасан энэ жил 14 дэх удаагийн нэгтгэл тайлан хийгдэнэ. Жил ирэх тусам тайлан сайжирч байгаа, мэдээллийг дамжуулах нь цаг хугацааны асуудал юм.

Ажлын албаны чадавхийг сайжруулах талаар санал нэгтэй байна. Ажлын алба УУХҮЯ-ны Сайдын мэдэлд ирсэн, энэ жил сонгуулийн жил байна. Сонгуулийн дараа Засгийн газрын шинэ бүтцэд Ажлын албыг бие даасан яамны аппарат байхаар орон тоо, бүтцийн санал оруулахаар бодож байгаа. Цаашдаа жил бүр сайдын багцад төсөв нь батлагдаад явна, 2021 оны 10 дугаар сар хүртэл АХБ-ын санхүүжилтээр хэрэгжихээр байгаа. Жил гаруйн хугацаа байна үүнээс өмнө сайдын багцдаа төсвөө яаж тусгах вэ гэдгийг төлөвлөх хэрэгтэй. Энэ жилээс эхлээд яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд тусгагдаад цаашид улам чанаржаад явна гэж ойлгож байна. Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тодорхой санал хэлсэн Та бүхэндээ баярлалаа.

Хуралдаан 16.30 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга

Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:

УУХҮЯ-ны Эдийн засаг, хөрөнгө оруулалт, Судалгааны хэлтсийн дарга:

Д.Дамба

Тэмдэглэлийн хянасан:

ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны Санхүүгийн ажилтан

А.Отгонтунгалаг

